



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 01/623

Хэрлэн сум

Шүүгчдийн бүрэлдэхүүн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1.3</sup>, 28<sup>1.1.10</sup> дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Хэнтий аймгийн ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026" бодлогын баримт бичиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2017 оны төсөв батлах тухай" 2016 оны 02 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хэнтий аймгийн ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026" бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын дунд зохион байгуулагдах "Тогтвортой хөгжлийн боловсрол"-ын олимпиадын шүүгчдийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Шүүгчдийн

бүрэлдэхүүн:

Д.Мөнгөнцэцэг

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
Ойн албаны дарга, ахлах мэргэжилтэн

Б.Гантөгс

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хяналт үнэлгээ шинжилгээ, дотоод  
аудитын хэлтсийн мэргэжилтэн

Я.Батбилэгт

-Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн

Ж.Уртнасан

-Ахмад багш /Зөвшилцсөнөөр/

Г.Баатарсүх

-Ахмад багш /Зөвшилцсөнөөр/

Б.Оюунтамир

-Зураач /Зөвшилцсөнөөр/

2. "Тогтвортой хөгжлийн боловсрол"-ын олимпиадад оролцогчдыг зохих шалгуур үзүүлэлтийг дүгнэн шалгаруулж, олимпиадтай холбоотой тайлан мэдээг аймгийн Засаг даргад танилцуулахыг шүүгчдийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 60